

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн Өмчит Аж Ахуй Төрийн Үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ИЧИНХОРЛОО ТАНАА

2020.03.13 № 06/844
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон бусад хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирал Б.Ичинхорлоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн дараах зөвлөмжүүдийг авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, газрын гэрчилгээг гаргуулах, худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, программын хөгжүүлэх, сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд Үндэсний аудитын газартай байгуулсан гуравласан гэрээг үндэслэн аудит хийлээ.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 25-аас 2020 оны 3 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, "Мэдээлэл-Аудит"ХХК-ийн аудитор Н.Ганданбаавар, аудитор Д.Туяа, шинжээч Ц.Отгонжаргал, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн ДБ05/86 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад улсаас Монгол улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар, ОУ-ын байгууллагын төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардлагатай нийтлэг үйлчилгээг үзүүлэх, гадаад улс дахь дипломат төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэх, өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах, дипломат байгууллагуудад үзүүлдэг цогц үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, өрсөлдөх чадвар, мэргэшсэн хамт олныг бий болгон, Монгол улсын гадаад харилцааны салбарт хувь нэмрээ бэхжүүлэн ажиллах” гэсэн зорилго, зорилтын хүрээнд дараах нийтлэг үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, Олон Улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын барилга байгууламж, цахилгаан, сантехникийн засвар үйлчилгээ, тохижилт;
- Монгол Улсад зохион байгуулагдаж буй төрийн бүх түвшний айлчлал, хүндэт зочид төлөөлөгчид, Гадаад харилцааны яам, Монгол улсад суугаа Элчин сайдын яамд, Консулын газрууд, Олон Улсын байгууллагын төлөөлөгчийн газрын захиалгын дагуу автомашины үйлчилгээ;
- Дипломат төлөөлөгчийн газрууд нь Төрийн тусгай хамгаалалттай объектуудад байршдаг ба Олон Улсын эрх зүйн актад тусгагдсан чиг үүргийн хүрээнд объектын бүрэн бүтэн байдал, тэдний ажиллах орчин нөхцөлийн аюулгүй ажиллагааг хуулийн хүрээнд сахин хамгаалах;
- Төрийн хэмжээний айлчлал болон Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчийн газруудын хүсэлтээр ёслол хүндэтгэлийн хүлээн авалт, арга хэмжээг зохион байгуулж чанар, стандартын өндөр түвшинд хүрсэн зоогийн үйлчилгээгээр үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Гүүк софт” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Axplorer 3.16” программ хангамж ашигладаг байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд аудитын 6 чиглэлд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,808.4 сая төгрөгөөс тооцон 56.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 107.2 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт зардал 5,388.0 сая төгрөгөөс тооцсонтой холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 805.8 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, дансны өглөг дансанд өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,412.5	2,807.2	394.7
Дансны авлага	797.5	731.5	(66.0)
Бараа материал	482.7	1,294.7	812.0
Үндсэн хөрөнгө	22,683.3	22,352.2	(331.1)
Биет бус хөрөнгө	2,624.8	2,621.0	(3.8)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,000.8	29,806.6	805.8
Дансны өглөг	57.4	789.0	731.6
Эздийн өмч	8,408.5	8,408.5	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,124.6	9,124.6	-
Хуримтлагдсан ашиг	11,410.3	11,484.5	74.2
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	29,000.8	29,806.6	805.8

Авлага дансны үлдэгдэл 731.5 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 66.0 сая төгрөгөөр буурсан нь харилцагч байгууллагаас авах авлага барагдсантай холбоотой. Байгууллагаас авах түрээсийн авлага 34.6 сая төгрөгөөр, татвар НД байгууллагаас авах авлага 5.5 сая төгрөгөөр, харилцагч байгууллагуудаас авах авлага 74.0 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос

буурсан боловч Элчин сайдын яамдаас авах авлага 27.9 сая төгрөг, 95 айлын орон сууцны суугчдаас авах авлага 20.2 сая нийт 48.1 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 812.0 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 120 дугаар тогтоолоор ТӨБЗГ-с буцалтгүй тусламжийн хүрээнд 5,441.5 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэж, 2019 оны А-1/3882 тоот албан бичгээр 4,680.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг балансаас балансад Гадаад харилцааны яаманд 884.1 сая төгрөг, Авлигатай тэмцэх газарт 331.2 сая төгрөг, Тагнуулын ерөнхий газарт 135.2 сая төгрөг, Цагдаагийн ерөнхий газарт 330.2 сая төгрөг, Радио, телевизийн сүлжээний газарт 723.1 сая төгрөг, Удирдлагын академид 199.9 сая төгрөг, Үндэсний батлан хамгаалахын их сургуульд 1,035.6 сая төгрөг, ЮНЕСКО-ийн үндэсний комисст 167.0 сая төгрөг, нийт 4,680.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, үлдсэн 760.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бараа материал дансанд бүртгэлтэй байна. Тайлант онд 46.3 сая төгрөгийн зочид буудал, зоог үйлчилгээнд шаардлагатай бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авсан нь бараа материалын үлдэгдэл өсөх шалтгаан болжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 331.1 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2018 оны 681 дугаар тогтоолоор батлагдсан 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 468.9 сая төгрөгийн их засварын ажил, гадна дулаан, цэвэр усны, гаднах цахилгааны шугам солих ажлын гүйцэтгэлээр үндсэн хөрөнгө нэмэгдсэн, тайлант оны элэгдлийн зардал 800.1 сая төгрөгөөр буурсан нь шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө нь тайлант оны хорогдлын зардлаар буурсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь бараа материалын үлдэгдэлд бүртгэлтэй байгаа 760.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт өгөх өглөгөөр бүртгэлтэй байгаа нь нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт өгөх өглөг нийт өр төлбөрийн 96.4 хувийг эзэлж байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 25-ны 681 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын зорилтот түвшнийг 5,823.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,789.5 сая төгрөгийн зардалтай, 34.2 сая төгрөгийн ашигтай байхаар баталсан байна.

Тайлант онд зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөө 94 хувиар биелсэн, зардлын гүйцэтгэл 93 хувь буюу 401.5 сая төгрөгийн хэмнэлттэй гарч, 89.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Үйлчилгээ, ашиглалтын орлого 73.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс тасарсан нь 2019 оны 3-р сараас эхлэн цахилгаан болон усны тариф нэмэгдсэн боловч ЭСЯамдуудаас авах ашиглалтын зардал, үйлчилгээний тариф өөрчлөгдөөгүй, бусад түрээсийн орлого 67.5 сая төгрөгөөр давсан нь 2019 оны 4-р сараас ОӨУБГазар, Жендерийн үндэсний хороо зэрэг байгууллагуудтай шинээр түрээсийн гэрээ хийсэн, бусад орлого 25.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс давсан нь банкны хүүгийн орлого, Дипломат 95 зочид буудалд засвар хийж тарифыг нэмсэн зэрэг нь тус тус нөлөөлжээ.

Зоог үйлчилгээний орлого 265.7 сая төгрөгөөр тасарсан нь Ханддоржийн өргөөг тогтмол ажиллуулахаар тооцоолсон ч түүхийн дурсгалт газарт байнгын хоолны газар ажиллуулж болохгүй гэсэн шалтгаанаас, авто баазын орлого 52.1 сая төгрөгөөр тасарсан нь тус авто бааз нь 2012 оноос хойш парк шинэчлэлт хийгээгүй бөгөөд нийт машинуудын 70 хувь нь норм хугацаа дууссан бөгөөд 2019 онд парк шинэчлэлт хийхээр төлөвлөж байсан боловч хийж чадаагүй тул гадаад, дотоодын зочин төлөөлөгчид үйлчлэх шаардлага хангахгүй байсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд 5,789.4 сая төгрөгийн үйл ажиллагаандаа зарцуулж, 30.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар батлагдсанаас 5,387.9 сая төгрөгийн зардалтай ажиллаж 401.6 сая төгрөгийн зардал хэмнэж ажиллан 89.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Ханддоржийн өргөөг тогтмол ажиллуулахаар тооцоолсон хангамжийн материал 163.6 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардал 148.5 сая төгрөг, гадаад албан томилолтын зардал 22.9 сая төгрөг, бичиг хэргийн зардал 6.1 сая төгрөг, элэгдлийн зардал 150.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажиллсантай холбоотой.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж 3 эрсдэл тодорхойлж, нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 319.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 250.0 сая төгрөгийн алдааг залруулж, 69.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайланд дараах алдааг залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд "Хүүгийн орлого" 142.1 сая төгрөг, гадаад валютын бодит бус олз 17.6 сая төгрөг, нийт 159.7 сая төгрөгийн орлогыг бусад орлогоор ангилан буруу тайлагнасан нь НББОУС-7 болон Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаал "Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын Тавдугаар бүлэг: Мөнгөн гүйлгээний тайлан" бэлтгэх зааврыг мөрдөж, мөнгөн гүйлгээг зөв ангилж тайлагнах гэсэн заалттай нийцээгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Тайлант онд гадаад валютын ажил гүйлгээний бодит бус олз 17.6 сая төгрөг буюу хойшлогдсон татварын өглөг 1.7 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд бүртгээгүй нь НББОУС-21 "Гадаад валютын өөрчлөлтийн үр нөлөө", НББОУС-12 Орлогын албан татварын бүртгэл зөрчигдөх, татварын эрсдэл үүсэх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 19.7 сая төгрөгийн зардлыг үйл ажиллагааны зардлаар бүртгэн үйл ажиллагааны үр дүнг буруу тайлагнаж, "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан"-д тайлагнаагүй байгаа нь ААНОАТ хуулийн 12 дугаар зүйл зөрчигдөх, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, татварын эрсдэл үүсэх

- Бусад хангамжийн материал дансанд 18 нэр төрлийн 68.9 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартын дагуу бүртгээгүй, үнэлгээ, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 69.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 120 дугаар тогтоолоор буцалтгүй тусламжийн хүрээнд 5,441.5 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын хөрөнгийн дансанд бүртгэж, 2019 оны А-1/3882 тоот албан бичгээр 4,680.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх шийдвэрийн дагуу шилжүүлж үлдсэн 760.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгө, бараа материалд бүртгэснийг дараагийн аудитаар биет горим гүйцэтгэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6.8 сая төгрөгийн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулсан, 7.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс хэрэгжүүлсэн байна.

Нийт 6 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг зөв ангилан бүртгэх, программ хангамжид хөгжүүлэлт, сайжруулалт хийлгэх 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 69.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 107.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Авлага данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Тайлант онд элчин сайдын яамдаас авах авлага 27.9 сая төгрөг, 95 айлын оршин суугчдаас авах авлага 20.1 сая төгрөг, нийт 48.0 сая төгрөгөөр өссөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Удирдлага ТӨБЗГ-тай байгуулсан контрактын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй байх

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

3.1.1. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.2. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

СБД-ийн 7-р хороонд байрлах ДБҮЭГ-ын 15-р байрны ...м2 газрын гэрчилгээг холбогдох байгууллагад хандаж гэрчилгээ гаргуулах талаар хандсан боловч одоо болтол гэрчилгээ гараагүй байгаа, гэрчилгээ гараагүй байхад хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн нь Сангийн сайдын 2018 он 207 тоот Аргачлал батлах тухай тушаалын 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйл Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний 4.5 дахь заалт "Газрын эзэмших, ашиглах эрхийг дахин үнэлэхдээ гэрчилгээгээр баталгаажсан газрын хэмжээнд... үндэслэн үнэлнэ"-заалтыг мөрдөж ажиллаагүй.

3.2.2. Эрсдэл:

Сангийн Яамнаас гаргасан холбогдох журам, заавар мөрдөгдөхгүй байх, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангахгүй байх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох байгууллагад хандаж газрын гэрчилгээг гаргуулах

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.3. *Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой асуудал*

3.3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд хувь хүнтэй 21.5 сая төгрөгийн барилгын материал шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.2 дугаар заалт “*Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар*”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг*” заалтыг зөрчсөн байна.

3.3.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгож худалдан авалт хийсэн байх

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ыг баримталж худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.4. *Програм хангамжтай холбоотой асуудал*

3.4.1. Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамжид хөгжүүлэлт, сайжруулалт хийлгээгүйгээс санхүүгийн тайлан зөрүүтэй татагдах, тодруулга тайлангуудыг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэж гаргаагүй нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн программ нь холбогдох хууль тогтоомж, НББОУС болон холбогдох заавар журамд нийцсэн байна гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Аж ахуйн нэгж байгууллага санхүүгийн тайлангаа Сангийн сайдын баталсан зааврын дагуу бэлтгэхгүй байх

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программыг НББОУС болон холбогдох хууль, журам, зааварт нийцсэн байхаар хөгжүүлэлт сайжруулалт хийлгэх, программын ашиглалтыг сайжруулах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.5. НБББББичигтэй холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлогийг тусгаагүй, одоо мөрдөж буй холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2-д Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг нь "... байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл:

НБББББ нь СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Яамнаас гаргасан холбогдох журам, зааварт нийцэхгүй байх;

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын онцлог, холбогдох стандарт, хууль журмыг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.6. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн дүн 5,857.9 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүн 8,408.5 сая төгрөг буюу 2,550.6 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна", 11.3-т "...11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15-ны өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Улсын бүртгэлийн тухай хууль зөрчигдөх, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангахгүй байх

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн өөрчлөлтийг хийлгүүлэх

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

3.7. Дээд шатны хяналттай холбоотой асуудал

3.7.1 Илрүүлэлт:

2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний орлогын төлөвлөгөөний биелэлт 94 хувь, зардлын гүйцэтгэл 93 хувь байгаа нь зоогийн үйлчилгээний орлого, зардлыг өмнөх оноос 37 хувиар өсгөж төлөвлөснөөс гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө биелээгүй, зардал хэмнэгдсэн байгаа нь төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслээгүй, бараа үйлчилгээний үнэ тарифын өсөлт бууралт, зах зээл дээр өрсөлдөж буй ижил төрлийн бараа, үйлчилгээний нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлын харьцуулалт, хөдөлмөрийн бүтээмжийн хэлбэлзлийг тооцсон шинжилгээ, судалгаа хийгээгүй байгаа нь *Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 681 тоот тушаалыг* хэрэгжүүлж ажиллаагүй.

3.7.2. Эрсдэл:

Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг биелүүлээгүй байх

3.7.3. Өгсөн зөвлөмж:

Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө боловсруулахдаа өмнөх оны төлөвлөгөөний гүйцэтгэл, бараа үйлчилгээний үнэ тарифын өсөлт бууралт, зах зээл дээр өрсөлдөж буй ижил төрлийн бараа, үйлчилгээний нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлын харьцуулалт, хөдөлмөрийн бүтээмжийн хэлбэлзлийг тооцсон шинжилгээ, судалгаанд үндэслэж гүйцэтгэх

3.7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,412,513,509.10	2,807,171,870.10
Дансны авлага	797,476,761.10	731,513,922.92
Татвар, НДШ-н авлага		
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	482,689,113.71	1,225,748,394.28
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,692,679,383.91	4,833,419,687.30
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	22,683,321,169.24	22,421,166,279.13
Биет бус хөрөнгө	2,624,800,356.20	2,620,981,808.27
Биологийн хөрөнгө		-
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,308,121,525.44	24,973,162,587.40
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,000,800,909.35	29,806,582,274.70
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	57,351,654.64	780,802,098.99
Цалингийн өглөг		
Татварын өр		8,390,777.63
Богино хугацаат өр төлбөрийн дүн	57,351,654.64	789,192,876.62
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Хойшлогдсон татварын өр		1,762,721.4
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	1,762,721.43
Өр төлбөрийн нийт дүн		790,955,598.05
Эздийн өмч		
Өмч : - төрийн	8,408,507,916.35	8,408,507,916.35
- хувийн		
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,124,607,661.22	9,124,607,661.22
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	11,410,333,677.14	11,482,511,099.08
Тайлангийн үеийн ашиг	116,080,861	89,885,140.37
Өмнөх үеийн ашиг	11,292,282,221	11,392,625,958.71
Эздийн өмчийн дүн	28,943,449,254.71	29,015,626,676.65
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	29,000,800,909.35	29,806,582,274.70

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	5,266,473,979.51	4,266,533,131.99
Борлуулалтын өртөг		-
Нийт ашиг (алдагдал)	5,266,473,979.51	4,266,533,131.99
Түрээсийн орлого		
Хүүний орлого	157,223,128.67	142,140,633.15
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		1,063,743,253.73
Борлуулалт, маркетингийн зардал	3,459,457,897.00	3,488,429,973.75
Ерөнхий ба удирдлагын зардал	1,571,846,808.55	1,843,983,515.93
Санхүүгийн зардал		
Бусад зардал	58,108,415.67	55,568,815.15
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	14,080,866.50	17,627,214.27
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(217,196,568.81)	
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	131,168,284.65	102,061,928.31
Орлогын татварын зардал	13,116,828.47	12,176,787.94
Татварын дараах ашиг (алдагдал)	118,051,456.19	89,885,140.37
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	118,051,456.19	89,885,140.37
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	6,433,294,901.42	6,051,238,260.44
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,782,158,931.80	3,197,105,106.45
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	2,651,135,969.62	2,854,133,153.99
Мөнгөн зарлагын дүн (-)	5,078,274,178.28	5,286,187,252.43
Ажиллагчдад төлсөн	1,408,631,750.29	1,589,674,454.51
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	346,531,370.00	420,804,640.83
Бараа материал худалдан авахад төлсөн	489,362,285.73	606,425,835.11
Ашиглалтын зардалд төлсөн	1,839,465,209.92	1,857,525,756.15
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	95,980,367.07	61,044,220.00
Хүүний төлбөрт төлсөн		-
Татварын байгууллагад төлсөн	433,109,543.98	380,114,052.77
Даатгалын төлбөрт төлсөн	23,105,154.48	23,249,105.45
Бусад мөнгөн зарлага	442,088,496.81	347,349,187.61
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,355,020,723.14	765,051,008.01
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	142,140,633.15
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүгийн орлого		142,140,633.15
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	443,792,794.00	512,452,776.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	66,759,699.00	58,890,500.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	377,033,095.00	297,240,138.00
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		156,322,138.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(443,792,794.00)	(370,312,142.85)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	17,707,718.43
Төлсөн ногдол ашиг		17,707,718.43
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(17,707,718.43)
Валютын ханшийн зөрүү		17,627,214.27
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	911,227,929.14	394,658,361.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,501,285,579.95	2,412,513,509.10
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,412,513,509.10	2,807,171,870.10

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	5,843,643,916.35	-	-	4,971,927,181.81	-		8,557,022,286.82	19,372,593,384.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							2,735,259,934.13	2,735,259,934.13
Залруулсан үлдэгдэл	5,843,643,916.35	-	-	4,971,927,181.81			11,292,282,220.95	22,107,853,319.11
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				4,152,680,479.41			118,051,456.19	4,270,731,935.60
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт	2,564,864,000.00							2,564,864,000.00
Зарласан ногдол ашиг								-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8,408,507,916.35	-	-	9,124,607,661.22	-		11,410,333,677.14	28,943,449,254.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл	8,408,507,916.35	-	-	9,124,607,661.22	-		11,410,333,677.14	28,943,449,254.71
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							89,885,140.37	89,885,140.37
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт								-
Зарласан ногдол ашиг							17,707,719.43	17,707,719.43
17,707,719.43		-						
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8,408,507,916.35	-	-	9,124,607,661.22	-		11,482,511,099.08	29,015,626,676.65

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020-03-15

Аудитын нэр:

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код:

САГ-2020/48/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд элчин сайдын яамдуудаас авах авлага 27.9 сая төгрөг, 95 айлын оршин суугчдаас авах авлага 20.1 сая төгрөг, нийт 48.0 сая төгрөгөөр өссөн байна	48.0	Аудитын зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Б.Болдбаатар
2	СБД-ийн 7-р хороонд байрлах ДБУЭГ-ын 15-р байрны газрын гэрчилгээ байхгүй байхад хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн.	-	Аудитын зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Б.Болдбаатар
3	Тайлант хугацаанд хувь хүнээс барилгын материал 21.5 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.	21.5	Аудитын зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Б.Болдбаатар
4	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамжид хөгжүүлэлт сайжруулалт хийлгээгүйгээс санхүүгийн тайлан зөрүүтэй татагдах, тодруулга тайлангууд батлагдсан маягтын дагуу бэлтгэж гаргаагүй.	-	Аудитын зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Б.Болдбаатар
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлогийг тусгаагүй, одоо мөрдөж буй холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангахгүй байна.	-	Аудитын зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Б.Болдбаатар
6	Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн дүн, санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүн зөрүүтэй байна.		Аудитын зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Б.Болдбаатар
7	2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний орлогын төлөвлөгөөний биелэлт 94 хувь, зардлын гүйцэтгэл 93 хувь байгаа нь зоогийн үйлчилгээний орлого, зардлыг өмнөх оноос 37 хувиар өсгөж төлөвлөсөнөөс гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө биелээгүй, зардал хэмнэгдсэн байгаа нь төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслээгүй, бараа үйлчилгээний үнэ тарифын өсөлт бууралт, зах зээл дээр өрсөлдөж буй ижил төрлийн бараа, үйлчилгээний нэгж бүтээгдхүүнд ногдох зардлын харьцуулалт, хөдөлмөрийн бүтээмжийн хэлбэлзэлийг тооцсон шинжилгээ, судалгаа хийгээгүй байна.		Аудитын зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Б.Болдбаатар
	Нийт зөрчлийн дүн	69.5			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.